

## ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Д.Моломжамц\*, Х.Бумдэлгэр\*\*

**Хураангуй:** Өндөр насны тэтгэвэр нь зөвхөн эдийн засгийн асуудал төдий зүйл биш юм. Энэ бол хүний хөгшрөлтийн үйл явдтай холбоотой эрүүл мэнд, сэтгэл зүй, биологи, физиологийн өөрчлөлт, түүнийг давах туулахад нь туслах, өндөр настнуудад тааламжтай нөхцөлд үргэлжлүүлэн хэвийн амьдрах бололцоог бүрдүүлж өгөхтэй холбогдсон төрийн нийгмийн бодлогын нэн тулгамдсан чухал асуудал юм. Үүнтэй холбоотойгоор тэтгэврийн даатгалын тогтолцоо бүрэлдэн бий болсон бөгөөд энэхүү өгүүлэлд өндөр насны тэтгэврийн даатгалын талаарх үеийн эрдэмтдийн дэвшүүлсэн онол, үзэл баримтлалыг харьцуулан судалсан болно.

**Түлхүүр үгс:** тэтгэврийн даатгал, даатгалын тогтолцоо

## A STUDY OF THE THEORY OF PENSION INSURANCE SYSTEMS

**Abstract:** Old-age pensions are not only an economic problem but also an important public social policy that relates to the physiological, biological and psychological changes caused by aging, and helping the elders overcome these challenges so that they can live under pleasant conditions. Therefore, the pension insurance system was formed. In this article, the theories about pensions and the perspectives of the scholars who put forward the theories are compared and studied.

**Keywords:** pension systems, aging, retirement, life expectancy, adequacy of retirement incomes,

---

\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [molomjants0112@yahoo.co.jp](mailto:molomjants0112@yahoo.co.jp)

\*\* ХААИС, Эдийн засаг бизнесийн сургууль, (E-mail): [kh.bumdelger@gmail.com](mailto:kh.bumdelger@gmail.com)

## Удиртгал

Өндөр насны тэтгэврийн тухай ойлголт нь хүний хөгшрөлтийн үйл явцтай холбоотой биологи, нийгэм, эдийн засгийн асуудал юм. Хөгшрөлт бол хүний биологийн шинж чанараар зайлшгүй нөхцөлдсөн үйл явц учраас түүнийг хэрхэн шийдвэрлэх нь хүний нийгэм үүссэн цагаас эхлэн нийгмийн өмнө тавигдаж ирсэн тулгамдсан асуудлуудын нэг болсоор иржээ. Биологийн хүчин чадлаа алдаж өөрийгөө авч явахад бусдын тусламж дэмжлэг шаардлагатай болсон хүнийг нийгэм нь хэрхэн хүлээн авах, хөгшин хүн өөрийгөө нийгмийн өмнө яаж мэдрэх нь нийгмийн асуудал, ахмад хүмүүсийн хэвийн амьдралыг хангах нь хөгшрөлтийн эдийн засгийн асуудал юм.

Иймээс өндөр насны тэтгэврийн асуудлыг биологийн шинжлэх ухаан, нийгэм, сэтгэл судлалын шинжлэх ухаан, эдийн засгийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, арга зүйн уулзвар дээр авч судлах нь түүнийг цаашид боловсронгуй болгох арга замыг тодорхойлох чухал ач холбогдолтой.

**Биологийн шинжлэх ухааны онолоор өндөр насны тэтгэврийн ойлголтыг дараах байдлаар тайлбарласан байдаг. Үүнд:**

Нас ахих тутам хүний бие организмд гарах физиологийн өөрчлөлтүүд нь бие эрхтний биологийн үүрэг, бодисын солилцооны бууралтаар илэрдэг. Тайлбар толь бичигт “Хүний хөгшрөлт нь хүний бие организмын тогтолцоо хэсгүүд аажмаар муудах биологийн үйл явц” хэмээн тайлбарласан байна.

Хөгшрөлтийн үйл явцыг манай тооллоос өмнө, тухайлбал Аристотель, Гиппократын үеэс ХХ зууны 50 — аад он хүртэл хөгшрөлтийн биологийн онолоор тайлбарлаж байжээ. Дараа нь биологийн шинжлэх ухаанд хүний хөгшрөлтийн үйл явцын судалгааны хоёр онол гарч ирсэн. Энэ нь “Хөтөлбөржсөн хөгшрөлтийн үйл явц” ба “Хөтөлбөржөөгүй хөгшрөлтийн үйл явц”-ын онолууд юм. (Ingram, 1983) Хөтөлбөржсөн хөгшрөлтийн үйл явцын онолоор хөгшрөлтийн үйл явц нь генетикийн механизмуудтай холбоотой бөгөөд эдгээр механизмын үр дүнд амьд байгалийн хувьсал явагддаг гэсэн байр суурь баримталдаг. Тэд амьд эд эсийн үйл ажиллагаа зөвхөн түүний идэвхтэй амьдралын үйл явцын үед л байгалиас хөтөлбөрждөг байна. Үүндээ хөгжил, өөрөөр хэлбэл эд эсийн өсөлт болон дахин бүтээгдэх чадварыг хамруулж байна. Энэ онолын төлөөлөгчид өөрсдийн үзэл бодлоо байгальд үргэлж ердийн шилжилтийн хууль үйлчилж ирсэн бөгөөд цаашид үйлчлэх болно гэж тайлбарладаг.

Хөгшрөлтийн зарим онолууд, тухайлбал “цагны” онол хөгшрөлттэй холбоотой өөрчлөлтүүд биологийн хэмжүүрт хянагддаг бөгөөд түүний үндсэн үүрэг нь биологийн эд эсийн хөгжлийн “хуваарийг” бэлгийн боловсролд хүрэх буюу үржих чадвартай болох хүртэл хянах юм. Хөтөлбөр хэрэгжсэний дараа

аль эсвэл тийм хөтөлбөр байхгүй тохиолдолд гипоталамусын үйл ажиллагаа болон эндоген систем эвдэрч эд эсийн физиологийн үүрэг буурна (Козлов, 1999) гэж тэд үздэг байна.

“Хөтөлбөржөөгүй хөгшрөх үйл явц”-ын онолын талаас хөгшрөлттэй холбоотой өөрчлөлтийн явцад генетикийн програмд ороогүй хэдий ч эд эсэд програмчлагдсан бус нөлөө үзүүлдэг бусад механизмууд үйлчилдэг гэж тайлбарладаг. Ийм нөлөөлөл эд эс санамсаргүй гэмтсэн, молекулд гэнэтийн өөрчлөлт орсон тохиолдолд явагдах бөгөөд эдгээр нь эсийн бүтэц, түүний үүрэг болон бүр метаболизмын үйл явцыг өөрчилдөг. Энэ ердийн бус өөрчлөлтүүд нь өөртөө генетикийн мэдээллийг зөөвөрлөсөн ДНК-ийн молекулыг хөндөх боломжтой. Хэвийн метаболизмын үр дүнд эсийн хэмжээнд чөлөөтэй радикалын шинжтэй хортой нөлөөлөл бүхий бүтээгдэхүүнүүд үүсэх боломжтой. Эдгээрийн хортой нөлөөллийг эсийн хамгааллын механизмууд давах үүрэгтэй боловч чөлөөтэй радикалууд нь эсийн мембраныг гэмтээж генетикийн мэдээллийн ДНК-ийн зөөвөрлөлтөд алдаа оруулдаг ажээ.

Хөгшрөлтийн биологийн үйл явцын талаарх энэ хоёр онол хоорондоо салшгүй холбоотой бөгөөд хөгшрөхөд явагддаг хувьслын үйл явцын шалтгааны тухай үнэмшилтэй тайлбарыг өгдөг юм. Энэхүү онолд Оросын герентологийн үндэслэгч А.А.Богомольцын хөгшрөлтийг эд эсийн физиологийн процессийн гармоны алдагдалтай холбосон дүгнэлт, И.И.Мечниковын хөгшрөлтийг интоксикациин үйл явцтай холбож өгсөн тайлбарууд багтдаг. (Яцемирская & Беленькая, 1999) Хөгшрөх үйл явцын тухайд биологийн онол хамгийн үндэслэлтэй боловч биологийн онол нь дангаараа хөгшрөлтийн физиологи, сэтгэл зүйн хоёр талын хам нөлөөллийг болон хүний амьдралыг уртасгах сэтгэл зүйн хүчин зүйлсийг тооцоогүй байна.

Ферментийн идэвхжил болон түүний хронологийн настай хамаарал бүхий өөрчлөлтийг судалсны үндсэн дээр биохимийн онол боловсруулсан байдаг. (Stadtman, 1988) Энэхүү онолд орчин үед дундаж наслалтын биомаркерт ямар үзүүлэлтүүдийг оруулж үзэх, тэдгээр нь ямар шинж чанарыг илэрхийлж, ямар шалгууруудыг хангасан байх талаар хүлээн зөвшөөрсөн нэгдсэн ойлголтуудыг тодорхойлжээ. Биеийн эсүүдийн мутацийн онолоор хөгшрөлтийн үйл явцыг тайлбарлахдаа эсийн доторх гэмтлийн бай нь дезоксирибонуклейн хүчил болдог бөгөөд гадна, дотныг гэмтээгч хүчин зүйлийн нөлөөгөөр эсийн удмын материал гэмтэж, их биеийн эсүүдийн геномд санамсаргүй мутаци үүсэж хуримтлагдсанаас эс хөгширдөг гэж үздэг. Чөлөөт радикалын онолоор зөвхөн хөгшрөлтийн механизмыг тайлбарлаад зогсоогүй түүнтэй холбоотой бусад эрхтний тогтолцооны зүгээс гардаг эмгэг үйл явцуудыг тайлбарласан байдаг. Солбицон холбогдох онолоор хүний эд эсийн коллагений хөндлөн холбоос ихэссэнээс эсийн бодисын солилцоо хэвийн явагдаж эсэд тэжээлийн бодис

чөлөөтэй нэвтэрч эсээс бодисын солилцооны эцсийн бүтээгдэхүүнүүд гадагшлах нь саатна гэж тайлбарлажээ (Козлов, 1999).

Хүний хөгшрөлтийн үйл явцыг тайлбарлах онолуудыг дотор нь молекул биологийн болон физиологийн гэж хоёр үндсэн бүлэгт ангилж үзсэн. (Anisimov, 2007) Молекул биологийн онолд “Биеийн эсүүдийн мутацийн онол”, “Чөлөөт радикалын онол”, “Солбицон холбогдох онол” зэрэг чиглэлүүд хамрагддаг.

Харин хөгшрөлтийн физиологийн механизмын онол нь хөгшрөлтийг үндсэн хүчин зүйл болгож илчлэг ихтэй хүнс ба өтлөлт, өтлөлтийн дархлааны механизм, мэдрэл шингэний зохицуулга алдагдлын механизмуудыг авч үздэг байна.

Биологийн салбарын судлаачдын үзэж байгаагаар хөгшрөлт гэдэг нь бүх амьд амьтан, түүний дотор хүнийг ч хамарсан амьд эд эсийн үйл ажиллагаа болон хувьслыг харуулсан биологийн суурь үндсэн шинж юм. Биологийн чиглэлийн судлаачид хүний насны өөрчлөлтийн мөн чанар, шалтгаан, насны хэмжээ, хязгаар, хөгшрөлтийн үйл явцын үр дагаврыг хөнгөрүүлэх боломжийн талаас нь ойлгохыг оролддог байна. Гэхдээ хүний хөгшрөлтийн үйл явцыг зөвхөн амьд байгалийн биологийн ерөнхий зүй тогтлоор тайлбарлах нь учир дутагдалтай, хөгшрөлтийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг хамтад нь судлах хэрэгтэй. Шинжлэх ухаануудын нэгдэх, салбарлах хөгжлийн үр дүнд хүний хөгшрөлтийн асуудал анагаах ухааны судлах асуудлын хүрээнд шилжих үйл явц харагдаж байна.

**Нийгэм, сэтгэл судлалын шинжлэх ухааны онолоор өндөр насны тэтгэврийн ойлголтыг дараах байдлаар тайлбарласан байдаг. Үүнд:**

Хүний хөгшрөлтийн мөн чанар, шалтгаан болон механизм цаг хугацааны дагуу өөрчлөгдөж ирсэн. Энэ нь зөвхөн хүний биологи, физиологийн шинж чанараас гадна нийгмийн янз бүрийн сэтгэл зүйн хөгшрөлтийн онцлогтой нягт холбоотой байна.

Хүн нийгмийн амьтан болохын хувьд биологийн хуульд захирагдахын хамт нийгмийн хуульд захирагдан амьдардаг. Нийгмийн шинж чанартай янз бүрийн нөлөөллүүд хүний сэтгэл зүйгээр дамжин хөгшрөлтийн биологийн үйл явцад идэвхтэй нөлөө үзүүлдэг. Үүнтэй холбогдон хөгшрөлт болон хөгшрөх үйл явцын судалгаанд хөгшрөлтийн нийгэм, сэтгэл зүйн хандлагуудыг ашиглаж байна.

А.Адлер хүний зан төлвийн идэвхжүүлэлтийн үүргийг судлахдаа хүний амьдралын гол идэвхжүүлэлтийн хүч бол түүний өөрийнхөө дутмаг байдлыг мэдрэх гэсэн байна. Ямар ч хувь хүн ямар нэгэн байдлаар энэ мэдрэмжийг мэдрдэг. Адлерийн үзэж байгаагаар хувь хүн амьдралын бүхий л хугацаандаа энэ анх төрсөн дутмаг байдлаа ямар нэгэн байдлаар нөхөх гэж оролддог. А.Адлерын онол хөгшрөлтийн сэтгэл зүйн асуудлыг боловсруулахад ихээхэн нөлөөлсөн. (Выготский, 1984)

Хөгшрөлтийн бие бялдрын болон физиологийн боломжуудыг бууруулах нөхцөл нь урьдын амьдралын хэв маягаар амьдарч чадахгүй болгоход хүргэж ямар нэгэн зүйлийн шаардлагаас татгалзах, ямар нэгэн зүйл өөрчлөхөд хүргэдэг. К. Юнг “Амьдралын хоёр дахь хагас” гэж нэрлэн энэхүү асуудлыг судлахдаа их ач холбогдол өгч байсан. Хүн амьдралын хоёрдугаар хагастаа хувь хүний хувьд шинэ бүрэн дүүрэн хөгжлийг олох боломжтой. (Юнг,1999) Юнгийн үзэл бодлоор өөрийн амьдралд зорилготой үзэл бодол боловсруулах хэрэгцээ, өөрийн дотоод ертөнцдөө хандах, өөрийгөө олох бол хөгшрөлтийн үүрэг бөгөөд шаардлага юм. Тэрээр хүний амьдралын төгсгөл нь амьдралын гэрэл гэгээний өрөвдмөөр үр дагавар биш, харин өөрийн гэсэн утгатай байх ёстой гэж үзэж байсан. Ийм учраас хөгшрөлтийн явцад удаарлалт ихсэх нь амьдралын хоёрдугаар хагастаа хүмүүс бэлтгэгдээгүй ордогийн үр дагавар гэж үзжээ.

К.Ясперс хөгшрөлтийг амьдралын таатай болон хэвийн үе шат гэж үзсэн. Тэрээр бичихдээ хөгшрөлтийн явцад ур чадвар буурдаг хэдий ч баялаг их хэмжээгээр хуримтлагддаг, биеэ барих байдал, амьдралын хэв маяг, өөрийгөө удирдах байдал зэргээрээ давуу чанартай болдог. Ийм учраас хөгшрөлтөөс айх хэрэггүй, түүнд өөрийн давуу талууд байдаг. Иймээс хүнийг амьдралын бүхий л үе шатанд зовоодог үхлийн аюул тийм чухал биш. Хөгшрөлт сайхан байж болно. Хүн бие бялдрын хувьд сул бөгөөд урьдын адил биеийн жаргал эдлэхгүй байж болох боловч захиргаадалтаас чөлөөтэй байж ингэснээр урьдын амьдралаасаа илүү амьдрах боломжтой. (Кагермазова, 1996)

А.Маслоу хүний зан үйлийн сэдлийн онолуудыг ерөнхийд нь “хэрэглээний”, “хүмүүнлэгийн” гэж хоёр хувааж авч үзсэн. Тэрээр хэрэглээний шатлалын онолдоо нийгмийн хамгааллын бүтэц тогтолцоо ямар байх, иргэддээ хэрхэн яаж үйлчлэх тухай онолын үзэл баримтлалыг өөрсдийн хийсэн судалгаагаар нотлон гаргажээ. (Оюунчимэг, 2010)

Э.Фромм нь нийгэм, хувь хүн хоёрын харилцаа, хувь хүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар судалж өөрийн дүгнэлтийг хийсэн байна. (Фромм,1990) Эндээс үзэхэд хувь хүний сэтгэл зүй нь эдийн засаг-нийгмийн хөгжилд шийдвэрлэх нөлөөтэй болох нь харагдаж байна.

Э.Эриксоны тодорхойлсон хувь хүний хөгжлийн найман үе шат хөгшрөлтийн судалгаанд хамгийн их хувь нэмрийг оруулсан байна. Амьдралын мөчлөгийн үе шат болгон тусгай зорилготой бөгөөд тэр нь нийгмээс дэвшүүлэгдэнэ. Үе шат болгон аливаа нийгмийн үнэт чанарыг олохдоо тодорхой зорилготой байна. Амьдралын найм дахь үе шат нь хөгшрөлт юм. Э.Эриксоны үзэж байгаагаар өмнөх амьдралын шатуудаа амжилттай дүүргэсэн хүмүүс л хөгшрөлтийн явцдаа амьдралаар хангалуун, үүргээ гүйцэтгэсэн мэдрэмжтэй байна гэж үзжээ. Хэрвээ өмнөх насны үе шатууддаа гол гол зорилтуудаа хэрэгжүүлж чадаагүй бол хөгшрөлтийг сэтгэл уналт, гуниглал болон үхлээс айх зэрэг дагалдана.

Э.Эриксоны онол сэтгэл зүйчдийн анхаарлыг ихээр татаж Р.Пек цаашид хөгжүүлсэн билээ. Р.Пекийн үзэж байгаагаар “амжилттай хөгшрөлтийн” гол үндэс бол хүн түүнийг хувь хүнийх нь хувьд хэмжих гурван зорилтыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн.

Нэгдүгээрт, хүмүүс тэтгэвэрт гарахдаа чөлөөт цагийг идэвхтэй үйл ажиллагаанаас салгахгүйн тулд өөртөө чухал үйл ажиллагааны төрлүүдийг тодорхойлох ёстой. Хэрвээ хүмүүс өөрийгөө зөвхөн ажил болон гэр бүлийнхээ хувьд л тодорхойлж байвал тэтгэвэртээ гарсны дараа ажлаа солих эсвэл хүүхдүүд нь гэрээсээ явах зэрэгт сөрөг сэтгэл хөдлөл үүсч хувь хүн түүнтэйгээ эвлэрч чадахгүйд хүрнэ.

Хоёрдугаарт, хувь хүний ур чадварын харьцааны хэмжилт, өөрөөр хэлбэл хөгшрөлтийг дагах биеийн сулралт, өвчин болон бие бялдрын зовиурт анхаарлаа хандуулахаас зайлсхийх. Хөгшин хүмүүс юуны өмнө өөрийн биеийн мэдрэмж муудахыг даван туулах, өвчний мэдрэмжийг мартагнах болон амьдралын сайн сайхнаар сэтгэл хангалуун байх хэрэгтэй.

Гуравдугаарт, хөгшин хүмүүс үхэл зайлшгүй бүр тэр байтугай ойрхон гэдгийг мэдэрч байгаа хэдий ч хүүхдүүдийнхээ хүмүүжил, өөрийн ажил, санаа зэрэгт хувь нэмэр оруулснаар дээрх мэдрэмжээ хөнгөлөх боломжтой. Э.Эриксоны онолын дагуу үхлийг айдас болон гуниглалгүй угтаж байгаа хүмүүс өөрийн ойрын үхлээ тэдгээрийн дараа үлдэх үе залгамжлагчийн тухай бодлоор дамжуулан тайван угтдаг байна.

Биологичид хөгшрөлтийн тодорхойлолтыг сэтгэл зүйчдээс ч их хэмжээгээр хийдэг, харин нийгэм судлаачид тэр тодорхойлолтыг ердөө гаргадаггүй. Ингэхдээ сэтгэл зүйчид болон биологичид амьдралын үргэлжлэх хугацааг хамааралтай хувьсагчийн хувьд ашигладаг. (Биррен, 1999)

Хөгшрөлтийг дараах гурван бүрэлдэхүүн хэсэг бүхий үйл явц гэж үзсэн байдаг. (Кагермазова, 1996)

1. Эд эсийн насалттай холбоотой биологийн хөгшрөлтийн үйл явц
2. Нийгмийн хөгшрөх үйл явц
3. Сэтгэл зүйн хөгшрөх үйл явц

Сэтгэл зүйн хөгшрөх үйл явцын судалгааны явцад насжилтын үе шатны үр дагаврууд, тэдгээрийн харилцаа холбоог Ж.Тернер ба Д.Хелмс нар судалж үзсэн байна. Тэд сэтгэл зүйн хөгшрөх үйл явцыг харилцан холбоотой гурван үйл явцад хуваажээ: сэтгэл зүйн хөгшрөх үйл явц—хувь хүн яаж өөрийн хөгшрөх үйл явцыг төсөөлж байна; тодорхой шинжийг агуулсан сэтгэл зүйн хөгшрөлтийн өвөрмөц мэдрэмж (оюун ухааны чадварын бууралт, сэтгэл санааны явцуурал); мөн субъектив илэрлүүд юм.

Ийнхүү нийгэм, сэтгэл судлалын шинжлэх ухааны сэтгэлгээний

урсгалуудад хөгшрөлтийн явцад үүсэх мэдрэмж, сэтгэл зүйн өөрчлөлт, тулгарч буй бэрхшээлийг даван туулах арга замыг авч үзэхийг чухалчилсан байна.

**Эдийн засгийн шинжлэх ухааны онолоор өндөр насны тэтгэврийн ойлголтыг дараах байдлаар тайлбарласан байдаг. Үүнд:**

Аристотель нийгмийг бүхэлд нь донсолгосон улс төрийн тэмцлийн шалтгаан нь эд хөрөнгийн тэгш бус байдалтай холбоотой гэж үзээд “Сайн төр”-ийн тухай үзэл санааг дэвшүүлсэн байдаг. Энэхүү “Сайн төр”-ийн зорилгод ахмад настантай холбоотой тэгш бус байдлыг нийгмийн хамгаалаар шийдвэрлэх боломжтой, үүнд төрийн оролцоо зайлшгүй гэсэн санааг илэрхийлжээ.

А.Смит “эдийн засгийн либерализмын үзэл баримтлалыг томъёолохдоо ... хувийн аж ахуй, пүүсүүд өрсөлдөөний үр дүнд өндөр ашигт хүрэхээр тэмүүлдэг. Төр нийгмийн ашиг сонирхлын төлөө сайн үйлийг зайлшгүй хийхийг ёс суртахууны үүднээс нотлох нь илүүц юм” гэж тэмдэглэсэн байна. А.Смитийн “нийгмийн ашиг сонирхлын төлөө төрийн үйлдэх сайн үйл”-ийн дотор ахмад настны нийгмийн хамгаалал хамрагдаж байгаа юм.

Д.Рикардо “Өртгийн үндэс-хөдөлмөр” хэмээх бүтээлдээ хуваарилалтын онолыг боловсруулсан билээ. Тэрээр энэхүү онолдоо нийгмийн бүтээгдэхүүний хуваарилалтын асуудлыг дэвшүүлэн тавьж түүнийг шийдвэрлэхэд шинжлэх ухааны хувьд үнэ цэнэтэй алхмуудыг хиймэн. Үүнээс үзвэл, нийгмийн баялгийн хуваарилалтад төр оролцож хүмүүсийн амьдралын тэгш бус байдлыг өөрчлөх нь хүн амын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх арга юм.

С.Симон “Аж үйлдвэрлэлийг феодалын хязгаарлалтаас чөлөөлөх” хэмээх бүтээлдээ нийгмийн тэгш бус байдлыг төрийн оролцоотой даван туулахтай холбоотой зарчмыг боловсруулан түүндээ тулгуурлан нийгмийн хамгааллын арга зүйн үндсийг боловсруулсан.

Ш.Фурье 1808 онд “Бүх нийтийн хувь заяаны онол”-ыг боловсруулж, нийгмийн шинжлэх ухааныг хөгжүүлэхдээ өөрийн амьдарч байсан үеийн нийгмийн хувьсал, өөрчлөлтийн хүрээнд ажил эрхлэгч иргэд, эздийн хооронд үүсэж байгаа зөрчлийг арилгахад төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний төрөл хэлбэр, хэм хэмжээг тодорхойлсон.

С.Сисмонди 1819 онд эдийн засгийн онолын жинхэнэ объект нь баялаг биш, хүн юм гэдгийг баталсан байдаг. Үүнээс үзэхэд аливаа баялаг нь бидний олж эзэмшихийг хүсэж байгаа зүйлсээс, өөрөөр хэлбэл хүний хэрэгцээг шууд ба шууд бус замаар хангадаг зүйлсээс бүрэлддэг. Үүнтэй холбоотойгоор баялгийг бүтээхэд оролцож байгаа, эс оролцож байгаагаас үл хамааран нийгмийн баялгийн хуваарилалтад оролцох эрхтэй гэсэн үндэслэл гарч байна.

К.Маркс “Капитал”, “Хөлсний хөдөлмөр ба капитал” зэрэг бүтээлүүддээ тусгасан зүүний буюу нийгмийн хамгааллын тухай ардчилсан социалист онол, арга зүй нь орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны сэтгэлгээнд томоохон

байр суурь эзэлдэг бөгөөд энэ нь онолын сэтгэлгээний ололт байсан төдийгүй, “Ардчилсан социалист үзэл буюу Шведийн загварын хувилбар”-аар нийгмийн хөгжилд бодит биеллээ олжээ. Энэ онол нь иргэн бүрийн ажил эрхлэлт, чинээлэг хангалуун амьжиргаа, олон ургальч үзэл, улс төрийн ардчилал, байгаль орчны хамгаалал зэрэг асуудлуудыг хамарч байжээ.

А.Штейн хөлсний ажилчдын цалинг даатгах институт үүссэнтэй холбогдуулан төрийн нийгмийн үүргийн тухай болон төрөл бүрийн эрсдэлд өртөгсдийг төрөөс тэтгэх үзэл санааны элементүүдийг тодорхойлсон бол А.Пигу хүмүүсийн амьдралын тэгш бус байдлын талаар төрөөс тодорхой зохицуулалт хийж болох тухай үзэл санааг дэвшүүлсэн.

Ж.Кейнс 1936 онд бичсэн “Ажил эрхлэлт, хүүгийн түвшин ба мөнгөний ерөнхий онол” бүтээлдээ эдийн засгийн өсөлтийн онолыг үндэслэж, хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулан, шаардлагатай зүйлд төрийн зүгээс тусламж үзүүлэх нь зүйтэй гэж үзжээ. Эндээс дүгнэхэд хувийн тэтгэврийн даатгалын компаниудын үйл ажиллагааг дэмжин, хууль эрх зүйгээр хангаж хамтарч ажиллавал илүү үр дүнд хүрч болох юм.

Тэтгэврийн ихэнх хангамж нь өмнөх орлоготой нь харьцуулахад хэр ашиг тустай байх вэ гэдэг дээр анхаарч тогтоодог. Түгээмэл ашигладаг ихэнх тогтоолт буюу арга хэмжээ нь орлуулах хэмжээ байдаг гэж үзжээ. (Л.Колиткофф, 1999) Эндээс үзэхэд тэтгэврийн өмнөх орлогын боломжийн хэсгийг нөхөн олгох нь зүйтэй мөн насан туршийн хэрэглээтэй тэнцэхээр хэмжээтэй байх хэрэгтэй гэсэн асуудал дэвшүүлсэн байна.

Тэтгэврийн шинэчлэл болон нийгэм хамгааллын тогтолцооны асуудлуудыг шийдвэрлэхдээ үндсэн гурван салбарт хувааж судлах нь зүйтэй гэж үзсэн байна.

Үүнд:

- Макро эдийн засгийн хүрээнд
- Микро эдийн засгийн хүрээнд
- Улс төрийн эдийн засгийн хүрээнд нь судалснаар тус бүрд нь нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлсноор тэтгэврийн шинэчлэлийн үнэлгээнүүд нь бодитой гарч, цаашид боловсронгуй болгоход түлхэц болно гэж үзжээ. (Peter & Stiglitz, 1999)

Өндөр насны тэтгэврийн тогтолцоог шинэчлэхийн тулд загварт тохирсон олон янзын элементүүдийн нэгдмэл аргыг ашигласнаар амжилтад хүрнэ. Тухайлбал, тэтгэврийн системийн загварын зориулалт нь дараах асуудлуудыг хамарсан байвал зохистой юм. Үүнд:

1. Даатгуулагчийн гүйцэтгэх үүргийг ойлгомжтойгоор тусгах
2. Төрийн болон төрийн бус агентуудын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хянах асуудал



3. Хөрөнгө оруулалтын асуудал
4. Тэтгэврийн сангийн мөнгөн хөрөнгийг хуримтлуулж тооцоолох асуудал зэргийг нарийвчлан тусгаж өгснөөр шинэчлэл үр дүнтэй болох юм гэж үзжээ. (David, 2013)

Хүний хөгшрөлттэй хамт амьдралын түвшин буурах, түүнээс урган гарах ээдрээтэй асуудал, ялангуяа эрүүл мэнд доройтох, орлого, үйлчилгээ, ахуй хангамж багасах зэрэг үзэгдэл явагддаг. Ийм учраас ахмад настнуудад тааламжтай нөхцөлд хэвийн амьдрах бололцоог бүрдүүлж өгөх нь аль ч улс орны төрийн нийгмийн бодлогын нэн тулгамдсан асуудал юм. Чухам эндээс өндөр насны тэтгэврийн эдийн засгийн асуудал үүсэн гарсан билээ.

Эдийн засгийн онолын сэтгэлгээний хөгжлийн хандлагаас дүгнэж үзвэл, өндөр насны тэтгэврийн асуудал нь нийгмийн баялагийн хуваарилалтын үзэл баримтлалаар тайлбарлагдах нийгмийн хамгааллын асуудал юм.

О.Бисмарк анх 1889 онд эрчимтэй ажиллах насандаа өөртөө зориулан мөнгө хуримтлуулж, дараа нь тэтгэвэр авах зарчимд тулгуурласан, төрийн оролцоотой нийгмийн даатгалын хөтөлбөрийг үндэслэсэн байна. Түүний дэвшүүлсэн даатгалын системийн эх үүсвэрийг ажилчдаас ажил олгогчдод цалингаасаа төлдөг татвар болон төрөөс өгдөг хандиваас бүрдүүлэхээр төлөвлөж байжээ. Энэ үзэл санааны дагуу 1908 онд Англид өндөр насны тэтгэврийн анхны хууль гарсан.

Э.Дюркхейм нийгмийн даатгалын эв санааны нэгдлийн онолыг боловсруулсан бөгөөд үүний үндсэн агуулга нь өнөөгийн даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хөрөнгөөр өмнөх үеийн даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгох үйл явцаар илэрч байдагт оршиж байна. (Найжель, 2006) Уг онол нь олон оронд одоог хүртэл хэрэгжиж байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа улс орнууд нийгмийн даатгалын хөрөнгийн хуваарилалтын /эв санааны нэгдлийн/ аргаас татгалзан шилжилтийн тогтолцоо буюу “Хагас хуримтлал”-ын аргыг дамжин улмаар “Бүрэн хуримтлалын арга”-д шилжих боломж байгааг нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхийг санал болгожээ. (Бэндер, 1997)

Өндөр насны тэтгэврийг төрийн анхаарлаас гадуур орхисон нэг ч улс орон байхгүй байгаа нь эрт дээр үеэс нийгмийн баялгийн хуваарилалтад төр гарцаагүй оролцох ёстой гэсэн хуваарилалтын онолын үзэл баримтлал өнөөг хүртэл хэрэгжиж иржээ гэж үзэх үндэслэлтэй юм. Мөн үүнийг нөгөө талаас нь авч үзвэл дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжиж байгаа зарим улс орнуудад өндөр насны тэтгэврийн даатгалын үйл ажиллагааг зөвхөн төр төдийгүй аж ахуйн нэгж, санхүүгийн зарим байгууллагуудад эрхлэн явуулах боломж олгосон нь даатгалын үйл ажиллагаа чөлөөт өрсөлдөөний орчинд зах зээлийн үндсэн

зарчмын дагуу хөгжих онолын чиг баримжаа хэрэгжиж байгааг харуулж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн улс орнуудын зөвлөлдөх уулзалтаас тэтгэврийн даатгалын үндсэн зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 30-аас дээш жил төлсөн буюу эх орондоо 20-оос дээш жил амьдарсан иргэдэд тогтоогдсон дүрэм журмын дагуу өндөр насны тэтгэврийг олгоно;
- Тодорхой хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн мөн хөдөлмөрийн чадвартай байх үедээ татвар төлж байсан иргэд өндөр насны тэтгэвэрт хамрагдах эрхтэй;
- Мөн тогтоосон нас нь 65 наснаас хэтэрч үл болно;
- Гэвч эрх бүхий байгууллага нь тухайн орны өндөр настны хөдөлмөрийн чадварыг харгалзан насны хязгаарыг үүнээс дээгүүр тогтоож болно.

Энэхүү зарчмуудыг тэтгэврийн даатгалын асуудлыг нэг мөр болгон тогтоосон хэм хэмжээ гэж үзэж болно.

Мөн Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай конвенцид тэтгэвэр, тэтгэмжид зарцуулах хөрөнгө болон уг тэтгэвэр, тэтгэмжийг олгохтой холбогдсон захиргааны зардлыг даатгалын шимтгэл буюу татвараар, эсвэл энэ хоёр аргыг хослуулан хэрэглэх замаар бүрдүүлэх ба ингэхдээ тухайн гишүүн орны болон хамрагдсан хүмүүсийн эдийн засгийн байдлыг харгалзан үзэж, бага орлоготой хүмүүст хүндрэл учруулахгүй байхаар шийдвэрлэсэн байвал зохино гэж заажээ.

Гэхдээ дэлхий нийтэд өндөр насны тэтгэврийг хэрхэн шийдвэрлэх талаар амьдрал дээр туршигдан биеллээ олж онол болсон нэгдсэн нэг үзэл баримтлал одоо хэр нь байхгүй болох нь үе үеийн судлаачдын бүтээлүүд, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагуудын удаа дараагийн чуулга уулзалтаас гаргасан конвенц, зөвлөмжүүдээс харагддаг. Нийгмийн хамгааллын асуудалд улс орнуудын нийгмийн болон соёлын үнэт зүйлс, түүхэн уламжлал, институтууд, эдийн засгийн хөгжил зэргийг нь харгалздаг байхаар тусгасан байна.

Хөгшрөлтийн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх арга, хэлбэр нийгмийн хөгжлийн дагуу байнга боловсронгуй болж ирсэн байна. Хүн төрөлхтөн хөгшрөлтийн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх түүхийн гурван үе шат, гурван хэлбэрийг дамжин өнгөрсөн байна. Үүнд:

1. Ахмад үеийнхээ амьдралыг байгалийн шалгарлаар шийдвэрлэж байсан үе /байгалийн шалгарлаар шийдвэрлэх хэлбэр/: Оршин буй нийгэм нь иргэний төлөв байдлыг олоогүй, байгалийн төрхөө хадгалж буй үеийн ахмад хөгшин хүмүүс бол байгалийн шалгарлын замаар, жам ёсоороо хаягдаж хоцорч байжээ.
2. Ахмад үеийнхний амьдралын асуудлыг гэр бүл, овгийн хүрээнд

шийдвэрлэж байсан үе /гэр бүл, отог омгоор шийдвэрлэх хэлбэр/: Нийгэм нь тэр бүр олон талын хөгжлийг олоогүй эдийн засгийн асуудал гэр бүл, үр хүүхэд, отог овгийн хүрээнд шийдвэрлэгдэж байсан цагт нас хөгширсөн ахмад хүмүүсээ үр хүүхэд, садан төрлөөрөө халамжлан асарч, амьдралын асуудлыг нь шийдэж байв. Ингэхдээ нас хөгширч чадал доройтох үеэс нь хүүхэд асрах, хүмүүжүүлэх, гэр бүлийн хялбар ажил гүйцэтгүүлэх зэргээр ачааллыг нь дэс дараалан хөнгөрүүлж, дараа нь бүрэн асаргаанд авдаг байжээ. Ахмадууд нь ч залуучуудад зөвлөж туслах, сургах, туршлагаа өвлүүлэх зэргээр идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг учраас гэр бүлийн хүндтэй гишүүн байжээ.

3. Ахмад үеийнхний амьдралын асуудалд нийгмийн оролцоотой шийдвэрлэх үе /гэр бүл, үр хүүхэд болон нийгмээр хамтран шийдвэрлэх хэлбэр/: Нийгэм нь иргэний төлөв байдалд орж хөгжсөн үед ахмад үеийн асуудлыг шийдвэрлэхэд ах дүү, төрөл төрөгсдөөс гадна нийгмийн зүгээс зайлшгүй халамж анхаарал тавих шаардлага гарсан юм.

## ДУГНЭЛТ

Нийгмийн хамгааллын асуудал улс орон бүрд тухайн орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, улс төрийн байдал, үндэсний соёл, уламжлалт ёс зэрэг олон хүчин зүйлүүдээс хамаарч янз бүрээр тавигддаг боловч амьдралын аливаа хүндрэл, бэрхшээлд өртсөн нийгмийн гишүүдийг эрсдлээс хамгаалах, тэдэнд амьдралын боломж бололцоо олгох үйл явц нь адил юм.

Хүн бүр нийгмийн гишүүнийхээ хувьд нийгмийн хамгаалалд хамрагдах эрхтэй. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пактад хүн бүрийн нийгмийн хамгаалалд, түүний дотор нийгмийн даатгалд хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө хэмээн заажээ. Олон улсын байгууллагуудаас гаргасан эдгээр баримт бичгүүдийн агуулгыг нарийвчлан авч үзвэл ахмад настнуудын хувьд хүч чадал, эрүүл мэнд нь доройтож, бүтээмж буурснаас залуустай адил хөдөлмөрлөж, адил хувь хүртэх бололцоогүй, баялгийн хуваарилалтад тэгш оролцох боломжгүй болдог нь харагдаж байна. Иймд хүн амын нийгмийн хамгааллын асуудал, түүний дотроос өндөр насны тэтгэврийн даатгал нь нийгмийн тэгш бус байдлыг даван туулахтай холбоотой юм.

Хүн төрөлхтний түүхэнд өмнө нь илэрч байгаагүй, төдийлөн хөндөгдөөгүй боловч орчин үед улс орон бүрд нийтлэг шинжтэй болоод байгаа асуудлуудын нэг нь дэлхийн хүн ам хөгширч буй үйл явц юм. Ийм ч учраас өндөр настны нийгмийн хамгаалал, тэтгэврийн хэмжээ, тэтгэврийн даатгал, тэтгэвэр тогтоох нас зэрэг асуудлыг иж бүрэн цогц байлаар шийдвэрлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй хандах явдал туйлаас чухал байна.

**Ашигласан материал**

- Аристотель. (2003) Улс төр. (орч Даш-Ёндон Б.) УБ. 68-69
- Бурмаа Г. (2013) Монгол Улсад амьдралын даатгалыг хөгжүүлэх асуудалд. 81-85
- Гантөмөр Г. (2006) Монгол улсын нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь. 77-80
- Дагвадорж Ч. (2004) Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, харьцуулалт. 17-20
- Далхжав Д. (2008) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн удирдлагыг боловсронгуй болгох зарим асуудал. 14-23, 183
- Даш С., Чимэд Ү. (1980) Марксизмын өмнөх эдийн засгийн онолын сэтгэлгээний түүхэн хөгжилт. 137-139
- Кагермазова Л.Ц. (1996) Возрастная психология Электронный учебник. 276-278
- Кейнс Дж. (1936) “Хөдөлмөр бүрэн эрхлэлт ба хүү, мөнгөний тухай ерөнхий онол” 78-79
- Козлов А.А. (1999) Старость: социальная разобщенность или целостность. 80-96
- Крайг Г. (2000) Психология развития.
- Намсрай Б. (1999) Эдийн засгийн онолын түүх. 89-96
- Найжель Др. (2006) Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд (монгол орчуулга). 6-8
- Оюунцэцэг Г., Дагвадорж Ч. (2003) Нийгмийн халамжийн удирдлага, онол арга зүйн асуудлууд.
- Оюунчимэг Б. (2010) Сэтгэл судлалын хөгжлийн түүх III дэвтэр. 116-118
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. (2012) “Зөвлөмжүүдийн эмхэтгэл”.
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (1952) Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай конвенц, (№102) 71 дүгээр зүйл.
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (1967) Хөдөлмөрийн чадвараа алдсаны, өндөр насны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн тухай конвенц, (№128) 17 дугаар зүйл.

- Пигу А.С. (1985) Экономическая теория благосостояния. 25-26
- Сисмонди С.Де. (1819) Новые принципы политической экономии. 35-36
- Смит А. (1998) Үндэстнүүдийн баялаг. 27-28
- Уранцэцэг Л., Дэлгэржав М. (2012) Нийгмийн сэтгэл судлал.
- Фромм Э. (1990) Иметь или быть. 99-100
- Цэдэндагва Г. (2003) Эдийн засгийн ухаан /Эдийн засгийн сургаалын түүх, микро, макро эдийн засаг/
- Цэцэгмаа Ц., Мөнхцэцэг Ж. (2005) Геронтологи, Гериатрийн үндэс. 20-33
- Штейн А. (1876) Настоящее и будущее правовой научно-государственной Германии. 18-20
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пакт (1966) 9 дүгээр зүйл
- Эриксон Э.Г. (1996) Детство и общество. 6-22, 26
- Юнг К.Г. (1999) Психология бессознательного. 77-78
- Яцемирская Р.С., Беленькая И.Г. (1999) Социальная геронтология. 80-91
- Anisimov VN. (2007) Biology of aging and cancer. Cancer Control. 57-58
- David E.B, Roddy McKinnon (2013) The design and implementation of public pension systems in developing countries: Issues and options. 10-11
- Grech A.G. (2013) How best to measure pension adequacy. 5-8
- Ingram D.K. (1983) Toward the behavioral assessment of biological aging in the laboratory mouse: concepts, terminology, and objectives. Exp Aging Res, 9(4): 225-238
- Peter R. Orszag and Joseph E. Stiglitz (1999). Rethinking Pension Reform: Ten Myths About Social Security. 6-8
- Robert Holzmann, Richard Hinz. (2006) Old Age Income Support in the 21<sup>st</sup> Century, World Bank. 35-37
- Stadtman E.R. (1988) Biochemical markers of aging. Exp Gerontol, 23 (4-5): 327-347